



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 82

Номгон

Г
Орон нутгийн өмчит байгууллагуудын
акталсан хөрөнгөд хяналт тавьж, хөрөнгийг
хүлээн авч худалдан борлуулах, устгал хийх
байнгын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1, 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилтийг хангуулж орон нутгийн өмчит байгууллагуудын акталсан хөрөнгөд хяналт тавьж, хөрөнгийг жагсаалтаар хүлээн авч худалдан борлуулах, устгал хийх ажлыг зохион байгуулах байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Байнгын комиссын ахлагч: Т.Эрдэнэбат-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Л.Доржханд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Гишүүд: С.Готов-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч

Э.Цэнд-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч

Ч.Үйтүмэн-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Г.Цэдэндамбаа-“Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дарга

Ц.Баясгалан-“Цэвэр хот” ОНӨХХК-ний захирал

2. Байнгын комиссын ахлагч /Т.Эрдэнэбат/-д ДААЛГАХ нь:

2.1. Орон нутгийн өмчит байгууллагуудаас 2019 онд актлагдсан хөрөнгийг жагсаалтаар хүлээн авч устгал хийх ажлыг “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, “Цэвэр хот” ОНӨХХК-тай хамтран зохион байгуулж гарах зардлыг холбогдох байгууллагын зардлаас гаргуулж, ажлын тайланг тухай бүр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулсугай.

1130196

D:/2018/Alban bichig/th togtool-2019

2.2. Актлагдсан барилгын материал, тээврийн хэрэгслийг хүлээн авч тээвэрлэх зардлыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны төсөвт тусгаж ажилласугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

